



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 05 сарын 26 өдөр

Дугаар 0000-2025/09

Сүхбаатар сум

Баянгол сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн
Хяналт шалгалтын дүн

Нэг: Хяналт шалгалтын зорилго, хамарсан хүрээ, хугацаа, шалгуулсан
байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалт

1.1. Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн СХШ-2025/20/-ТШЗ дугаартай "Санхүүгийн хяналтын ажлын удирдамж"-аар Баянгол сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын санхүү төсвийн гүйцэтгэл болон Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиуд болон Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан эрх зүйн актуудын хэрэгжилтийг хянан шалгах, илэрсэн зөрчил дутагдалд дүгнэлт өгөх засаж залруулах зорилготойгоор хяналт шалгалт хийлээ.

1.2. Шалгалтыг Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын дотоод аудитор, СХШУБ Ц.Уртнасан 2025 оны 05 дүгээр сарын 05-ны өдрөөс ажлын 15 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

1.3. Шалгалтад Баянгол сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал (цаашид Баянгол сумын ИТХ гэх)-ын 2023 оны 04 сарын 01 өдрөөс 2025 оны 03 сарын 31 өдөр хүртэлх хугацааны санхүү, төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагааны баримт материал, тайлан тооцоог хамруулав.

1.4. Баянгол сумын ИТХ нь улсын бүртгэлийн 3741354 дугаар регистртэй, Төрийн сан дах үндсэн үйл ажиллагааны 100130854001 дугаартай данс, нэмэлт санхүүжилтийн 100130854401 дугаартай данснуудыг ашиглаж байна.

1.5. Баянгол сумын Төсвийн орлого, зарлага, тайлагналт, Төрийн сангийн харилцах дансанд 1-р гарын үсгийг Баянгол сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга Д.Мөнхжаргал, 2-р гарын үсгийг нягтлан бодогч Г.Ганзориг нар зурж төсвийн хөрөнгийг захиран зарцуулж байна.

1.6. Баянгол сумын ИТХ нь улс төрийн албан тушаалтан 1, төрийн захиргааны албан хаагч 2 нийт 3 хүний орон тоогоор үйл ажиллагаа явуулж байна.

4325001139

1.7. Баянгол сумын ИТХ нь хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал, дүгнэлт гаргах, Хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүрэг бүхий Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөл болон Нутгийн удирдлага, хууль зүйн бодлогын хороо, Дэд бүтэц хөгжлийн бодлогын хороо, Нийгмийн бодлогын хороо, ХАА, байгаль орчны бодлогын хороо Эдийн засаг төсвийн бодлогын хороо, Өргөдөл гомдлын бодлогын хороо зэрэг 6 бодлогын хороог байгуулж, хурлын тасралтгүй, байнгын үйл ажиллагааг ханган ажиллаж байна. /Хүснэгт 1 харуулав/

1.8. Сумын ИТХ болон ИТХ-ын Зөвлөлийн хуралдаан, багийн иргэдийн Нийтийн Хуралдаан, сургалт, бодлогын хороодын хуралдааны бэлтгэл ажлыг хангаж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих зэрэгт ажлын албаны зүгээс анхаарч ажилласан байна.

Хүснэгт 1.

№	Огноо	ИТХ -ын хуралдсан тоо	ИТХ-ын зөвлөлийн хуралдсан тоо	ИТХ-ын хороодын хуралдсан тоо	БИНХ-ын хуралдсан тоо
1	2023	3 /27 асуудал хэлэлцэж 25 тогтоол баталсан байна/	3	2 /2 удаагийн хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэж 9 ажил, арга хэмжээг хэрэгжүүлсэн/	2 /2 баг ИНХ-ын хуралдаан зохион байгуулсан/
2	2024	10 /54 асуудал хэлэлцэж 43 тогтоол баталсан байна/	10	3 /хяналт шалгалтын 3 ажил зохион байгуулсан/	1 /1 баг ИНХ-ын хуралдаан хийсэн/
3	2025 оны 1 улирал	2 /10 асуудал хэлэлцэж 10 тогтоол баталсан байна/	6	8 /хяналт шалгалтын 1 ажил зохион байгуулсан/	3 /3 баг ИНХ-ын хуралдаан хийсэн/

Хоёр. Шалгалтад хамрагдах асуудлууд

2.1 Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт

2.1.1 Баянгол сумын ИТХ нь санхүүгийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад санхүүгийн хууль тогтоомжийн хүрээнд УСНББОУС, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдлөг болгон нягтлан бодох бүртгэлийг хөтлөн явуулж байна.

2.1.2 Баянгол сумын ИТХ-ын төсвийн хөрөнгийг зарцуулах захиргааны шийдвэр гаргахдаа Захиргааны актад утга, агуулгын алдаагүй бодит нөхцөл

байдлыг тогтоосон эрх зүйн үндэслэл хэсэгт нарийвчилсан зохицуулалтай хуулийн заалт, болон хуулиар эрх олгосон захиргааны хэм хэмжээний актын зүйл заалтыг ашиглахгүй байгаа нь Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангахгүй байх эрсдэлийг дагуулж байна.

2.2. Батлагдсан төсөв, гүйцэтгэл зориулалтын дагуу зарцуулсан байдал

2.2.1 Батлагдсан төсөв:

Баянгол сумын ИТХ-ын тогтоолоор тус байгууллагын төсвийг санхүүжүүлэхээр 2023 онд 157,447.5 мянган төгрөг, 2024 онд 251,333.1 мянган төгрөг, 2025 онд 280,766.2 мянган төгрөгөөр тус тус баталсан байна.

Хүснэгт 2.

(мянган төгрөгөөр)

№	Огноо	ИТХ-ын тогтоолын огноо, дугаар	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү /Үлдэгдэл	Хувь
1	2023	2023 оны 08 сарын 16 өдрийн 72 тогтоол	157,447.5	135,009.2	22,438.3	85.7
2	2024	2024 оны 10 сарын 04 өдрийн 110 тогтоол	251,333.1	224,791.2	26,541.9	89.4
3	2025	2024 оны 12 сарын 30 өдрийн 18 тогтоол	280,766.2	57,664.2		
	2025 -1 улирал		89,237.2	57,664.2	31,573.0	64.6

2023 онтой харьцуулахад 2024 онд батлагдсан төсөвт орсон өөрчлөлт:

- Засгийн газрын 2024 оны 82 тогтоолын дагуу цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 57,949.2 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 7,243.5 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардал 12,250.0 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардал 435.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 11,988.5 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 4,000.0 мянган төгрөгөөр тус тус өссөн дүнтэй батлагдсан байна.

2024 онтой харьцуулахад 2025 онд батлагдсан төсөвт орсон өөрчлөлт:

- Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоол, 2024 оны 238 дугаар тогтоолыг тус тус үндэслэн 2025 онд цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 10,018.4 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 1,252.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн,
- Бүтцийн өөрчлөлтөөр гарсан улс төрийн албан хаагчид олгох тэтгэмж 13,120.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн,
- Хангамж, бараа материалын зардал 1,050.0 мянган төгрөг, норматив зардал 141.2 мянган төгрөг, томилолтын зардал 365.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 5,506.2 мянган төгрөг,

бараа үйлчилгээний бусад зардал 4,480.0 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 1,000.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн,

- Эд хогшил, урсгал засварын зардал 7,500.0 мянган төгрөгөөр буурч тус тус батлагдсан байна.

2.2.2 Төсвийн зардлын гүйцэтгэл:

Хүснэгт 3.

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	2023 он		2024 он		2025 оны 1 улирал	
		Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	157,447.5	135,009.2	251,333.1	224,791.2	89,237.2	57,664.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	157,447.5	135,009.2	251,333.1	224,791.2	89,237.2	57,664.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	157,280.8	135,009.2	251,083.1	224,591.2	75,867.2	44,794.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	85,521.6	72,821.5	143,470.8	123,197.0	38,372.4	27,637.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,690.3	9,092.2	17,933.8	14,262.4	4,796.1	2,488.3
2104	Хангамж, бараа материалын зардал	5,363.9	5,151.2	5,300.0	5,151.1	1,587.6	841.5
2105	Нормативт зардал	58.8	0.0	58.8	0.0	200.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	250.0	220.0	12,500.0	12,405.8	5,000.0	5,000.0
2107	Томилолт, зочны зардал	1,200.0	172.0	1,635.0	1,206.4	500.1	307.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,196.2	40,725.2	56,184.7	55,094.6	20,791.0	5,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,000.0	6,827.1	14,000.0	13,273.9	4,620.0	3,519.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	166.7	0.0	250.0	200.0	13,370.0	12,870.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	166.7	0.00	250.0	200.0	13,370.0	12,870.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	157,447.5	135,009.2	251,333.1	224,791.2	89,237.2	57,664.2
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	157,447.5	135,009.2	251,333.1	224,791.2	89,237.2	57,664.2

Төсвийн нийт зардлын гүйцэтгэлийг 2023 онд 135,009.2 мянган төгрөг буюу 85.7 хувь, 2024 онд 224,791.2 мянган төгрөг буюу 89.4 хувь, 2025 оны 1 улирлын байдлаар 57,664.2 мянган төгрөг буюу 64.6 хувиар тайлагнасан байна.

2023 онд нийт 22,438.3 мянган төгрөгийн хэмнэлттэй байгаа нь:

- ИТХ-ын нарийн бичгийн дарга солигдож цалингийн зөрүү үүссэн мөн хурлын албаны ажилтан ажлаа өгч, дараагийн ажилтан авах хүртэлх хугацаанд 1 хүний орон тоо сул байснаас шалтгаалж цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлаас 12,700.1 мянган төгрөгийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 1,598.1 мянган төгрөгийг хэмнэсэн,
- Хангамж, бараа материалын зардал 212.7 мянган төгрөг, норматив зардал 58.8 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 30.0 мянган төгрөг, томилолт, зочны зардал 1,028.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 3,471.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 3,172.9 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 166.7 мянган төгрөгийн тус тус зарцуулаагүй үлдэгдэлтэй холбоотой байна.

2024 онд нийт 26,541.9 мянган төгрөгийн хэмнэлттэй байгаа нь:

- Засгийн газрын 2021 оны 376 дугаар тогтоолын 2. “Энэ тогтоолын хавсралтад заасан сумд (аймгийн төвийн болон 6000-аас дээш хүн амтай)-ын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны орон тооны хязгаарыг 4 хүртэл, бусад сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны орон тооны хязгаарыг 3 хүртэл байхаар тогтоосугай.” заалттай нийцэхгүй 1 орон тоог /архивын ажилтан/ нэмж цалинг төсөвт батлуулж суулгаснаас шалтгаалж цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлаас 20,273.8 мянган төгрөгийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 3,671.4 мянган төгрөгийг хэмнэсэн,
- Хангамж, бараа материалын зардал 148.9 мянган төгрөг, норматив зардал 58.8 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 94.2 мянган төгрөг, томилолт, зочны зардал 428.6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 1,090.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 726.1 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 50.0 мянган төгрөгийн тус тус зарцуулаагүй үлдэгдэлтэй холбоотой байна.

2025 оны 1 улирлын байдлаар нийт 31,573.0 мянган төгрөгийн хэмнэлттэй байгаа нь:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлаас 10,734.6 мянган ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 2,307.8 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 746.1 мянган төгрөг, норматив зардал 200.0 мянган төгрөг, томилолт, зочны зардал 193.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 15,791.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 1,100.4 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 500.0 мянган төгрөгийн тус тус зарцуулаагүй үлдэгдэлтэй холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэлийг зардлын эдийн засгийн ангиллаар дүн шинжилгээ хийхэд төсвийн төлөвлөгөөг бодит тооцоо судалгаанд үндэслэн эдийн засгийн ангиллаар үнэн зөв төлөвлөж байх шаардлагатай байна.

2.2.3 Нэмэлт санхүүжилтийн дансанд:

2023 он, 2024 он, 2025 оны 1 улирлын байдлаар нэмэлт санхүүжилтийн дансанд орлого ороогүй байна.

2.3. Ажилтан албан хаагчдын цалин хөлсний тогтоолт, тооцоолт, олголтын байдал

ИТХ-ын даргын 2023 оны Б/01 дугаар, 2024 оны Б/01 дугаар, 2025 оны Б/02 дугаар захирамжаар ИТХ-ын нарийн бичгийн даргын цалинг, ИТХ-ын нарийн бичгийн даргын 2023 оны Б/05 дугаар, 2024 оны Б/01 дугаар, 2025 оны Б/02 дугаар тушаалаар хурлын ажлын албаны нийт ажилчдын цалинг тус тус шинэчлэн баталсан байна.

Ажиллагсдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдлыг хяналт шалгалтын явцад цалингийн дэлгэрэнгүй цэсээс хүн тус бүрийн албан тушаалын ангилал, зэрэглэл, батлагдсан цагийн тооцоо, нэмэгдэл суутгал, тооцох тушаал шийдвэртэй тулган баталгаажууллаа.

2.4. Орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт

Нягтлан бодох бүртгэлийг хөтлөх заавар аргачлал, бодлогын баримт бичигт тусгасан арга зүйгээр үндсэн хөрөнгийн ангилал, нэршлийг үнэн зөв хөтөлсөн, орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хэвийн байна.

Аудитын явцад санхүүгийн ажилтан албан хаагчидтай хамтарч үндсэн хөрөнгийн тооллого, тулган баталгаажуулалт хийсэн.

Үндсэн хөрөнгө:

Хүснэгт 4.

(мянган төгрөгөөр)

№	Үндсэн хөрөнгө				
	Огноо	Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	2023	21,336.4	25,910.5	0.0	47,246.9
2	2024	47,246.9	4,994.0	0.0	52,240.9
3	2025 - 1 улирал	52,240.9	5,000.	0.0	57,240.9

2023 онд үндсэн хөрөнгийн орлого:

- ✚ Батлагдсан төсвөөс дэлгэц 1, камер 8 /сургууль, цэцэрлэг/, 4GB хард, камерийн төхөөрөм 1, дектафон 1, явган хүний тэмдэг тэмдэглэгээ 25, хяналтын камер 7 /сумын хөдөлгөөн хянах/ /нийт дансны үнэ 25,910.5 мянган төгрөг/ худалдан авсныг санхүүгийн бүртгэл тайланд бүрэн тусгасан байна.

2024 онд үндсэн хөрөнгийн орлого:

- ✚ Батлагдсан төсвөөс зөөврийн компьютер 1, хэвлэгч 1 /нийт дансны үнэ 4,994.0 мянган төгрөг/ худалдан авсныг санхүүгийн бүртгэл тайланд бүрэн тусгасан байна.

2025 оны 1 улирлийн байдлаар үндсэн хөрөнгийн орлого:

- ✚ Батлагдсан төсвөөс зөөврийн компьютер 1, зурагт 1 /нийт дансны үнэ 5,000.0 мянган төгрөг/ худалдан авсныг санхүүгийн бүртгэл тайланд бүрэн тусгасан байна.

Бараа материал:

Хүснэгт 5.

(мянган төгрөгөөр)

№	Бараа материал				
	Огноо	Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	2023	4,110.7	28,507.9	28,507.9	4,110.7
2	2024	4,110.7	53,717.9	24,247.9	33,580.7

3	2025 - 1 улирал	33,580.7	3,299.8	3,299.8	33,580.7
---	-----------------	----------	---------	---------	----------

2025 оны 1 улирлын байдлаар 3,299.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, зарцуулсан нь баримтаар нотлогдож байна.

2.5. Өглөг, авлагыг санхүүгийн тайланд үнэн зөв бүртгэсэн байдал

2023 онд Сэлэнгэ аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газраас 600.0 мянган төгрөгийн санхүүжилт орж ирсэн ба хариуцсан мэргэжилтэн байхгүй шалтгаанаар оны эцэст төвлөрүүлж татуулсныг санхүүгийн тайланд авлагаар бүртгэсэн байна. 2024 он, 2025 оны 1 улирлын байдлаар тухайн дүнгээр авлагын үлдэгдэлтэй тайлагнасан байна.

2024 онд ажилчдын цалингаас ХХОАТ-ыг суутгасан боловч төсөвт төвлөрүүлээгүйгээс 2,245.7 мянган төгрөгийн, ажил олгогчоос төлөх НДШ-ийг дутуу шилжүүлж, 619.2 мянган төгрөгийн өр төлбөр тус тус үүсгэсэн боловч санхүүгийн тайланд тусгаагүй байна. Уг зөрчилд Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас албан шаардлага тогтоосон.

2.6. Өмнөх хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байдал

Төрийн аудитын газраас санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар илэрсэн зөрчил:

Хүснэгт 6.

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	2023 он			2024 он		
	Тоо	Дүн	Биелэлт	Тоо	Дүн	Биелэлт
Акт	1	1,245.7	100%			
Албан шаардлага	1	0.0	100%	2	7,500.6	100%
Зөвлөмж	1	2,938.9	100%			
Нийт дүн	3	4,184.6		2	7,500.6	

2023 онд:

- ИТХ-ын нарийн бичгийн дарга Д.Мөнхжаргалд 2016 онд олгогдсон туслах түшмэлийн зэрэг дэвийг /2016 оны 09 сард тус албанаас чөлөөлөгдсөн/ үндэслэн ахлах түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалын дөтгөөр зэрэг дэвээр тооцож, 1,245.7 мянган төгрөгийн нэмэгдлийг илүү олгосон зөрчилд төлбөрийн акт,
- Жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахын өмнө эд хөрөнгө, бараа материалын тооллогыг хийсэн, харилцагч аж ахуй нэгж, байгууллагуудтай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулсан нь баримтаар бүрэн нотлогдоогүй зөрчилд албан шаардлага,

- ИТХ-ын нарийн бичгийн даргын ЭБАТ-ны нэмэгдлийг гүйцэтгэж буй ажлын ачаалалтай уялдуулалгүй хэт өндөр буюу 40 хувиар тооцож, А.Бадамдорж, Д.Мөнхжаргал нарт нийт 2,938.9 мянган төгрөг тооцож олгосон зөрчилд зөвлөмж тус тус хүргүүлсэн ба акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангаж зөрчлийг арилгасан байна.

2024 онд:

- ИТХ нь ажилчдын цалингаас ХХОАТ-ыг суутгасан боловч төсөвт төвлөрүүлээгүйгээс 2,245.7 мянган төгрөгийн, ажил олгогчоос төлөх НДШ-ийг дутуу шилжүүлж, 619.2 мянган төгрөгийн өр төлбөр тус тус үүсгэсэн,
- Батлагдсан төсвийг зардлын бүлэг, эдийн засгийн ангилал болон хөтөлбөр хооронд гүйлгэн зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлаас цалингийн зардалд 1,973.4 мянган төгрөг, мэдээлэл сурталчилгааны арга хэмжээний зардлаас бараа үйлчилгээний бусад зардалд 780.0 мянган төгрөг, багаж, техник хэрэгсэл худалдан авах зардлаас урсгал засварын зардалд 1,296.8 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас бага үнэтэй, түргэн элэгдэх, эд зүйлс худалдан авахад 165.0 мянган төгрөгийг, бичиг хэргийн зардалд 420.5 мянган төгрөг гэх мэт нийт 4,635.7 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага тус тус хүргүүлсэн ба албан шаардлагын хэрэгжилтийг бүрэн хангаж зөрчлийг арилгасан байна.

2.7. Дотоод хяналт шалгалтын үр нөлөө

Баянгол сумын Засаг даргын орлогчийн баталсан санхүүгийн албаны дотоод хяналтын төлөвлөгөөний дагуу сумын ИТХ-д 2024 онд ажлын байрны цаг ашиглалт, цалингийн тооцоололт, агуулахын бүртгэл, шилэн дансны бүртгэл дээр дотоод хяналт хийгдсэн байна.

Гурав. Шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, илэрсэн зөрчил дутагдал

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас Баянгол сумын ИТХ-ын ажлын албаны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нар төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн хууль, холбогдох журам зааврын дагуу төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж тайлагнасан, өмч хөрөнгийг данс бүртгэлд бүрэн тусгасан байна.

Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдалд Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас 2023 онд акт, албан шаардлага, зөвлөмж, 2024 онд албан шаардлага өгсөн тул зөрчлийг давхцуулж тооцоогүй болно.

Дөрөв. Дүгнэлт, шийдвэрлэлт:

4.1 Дүгнэлт:

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан удирдамжаар Баянгол сумын ИТХ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан хугацааны төсөв, санхүүгийн гүйцэтгэл, бүртгэл тайлагналт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр “Дунд” эрсдэлтэйд тооцож, төсвийн сахилга бат, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж дүгнэлээ.

Тав. Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж:

Шалгалтын явцад тус байгууллагын дарга, нягтлан бодогч, шалгалтаар илэрсэн зөрчилд хамаарал бүхий холбогдох албан хаагчтай уулзаж асуулга, тодруулга авч Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа явуулсан болно.

Шалгалтаар илэрсэн зөрчилт үйлдлүүд нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөл болох тул холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилт, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журамд нийцүүлэн ажиллах шаардлагатай байгааг тус сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга, нягтлан бодогч, бусад холбогдох ажилтнуудад танилцуулж, шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг анхаарууллаа.

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД
АУДИТЫН ГАЗРЫН ДОТООД
АУДИТОР, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ
Ц.УРТНАСАН



ТАНИЛЦСАН:

БАЯНГОЛ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Д.МӨНХЖАРГАЛ
НЯГТЛАН БОДОГЧ
Г.ГАНЗОРИГ

